# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН 2025.



# Агуулга.

03 Удирдлагын мэндчилгээ

04 Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйл

06 2025 оны онцлох үзүүлэлтүүд

07 БОНЗ ба компанийн засаглал

09 Тогтвортой үйл ажиллагаа ба санхүүжилт

17 Тогтвортой хөгжлийн алсын хараа



# Гүйцэтгэх захирлын мэндчилгээ.

Эрхэм хүндэт харилцагч, түнш, хөрөнгө оруулагч та бүхэндээ,

2025 он бол бидний хувьд **тогтвортой хөгжлийг бизнесийн стратегийнхээ үндсэн тулгуур болгосон** үе шат боллоо. Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмыг өдөр тутмын шийдвэр, бүтээгдэхүүний шинэчлэл, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд бүрэн уялдуулж хэрэгжүүллээ.

Тайлант онд ногоон зээлийн багцаа өргөтгөн, дижитал үйлчилгээгээр цаас, нүүрстөрөгчийн ялгарлыг тууштай бууруулсан. Хамт олноо 703 хүртэл өсгөн 108 шинэ ажлын байр бий болгож, Net Future 50 хөтөлбөрөөр залуу мэргэжилтнүүдийг дэмжиж, “Хайраар дүүрэн 24 зүрх” санаачилгаар 24 хүүхдийн зүрхний хагалгааны зардлыг бүрэн ивээн тэтгэв.

Засаглалын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх Тогтвортой хөгжил, нийгэм, засаглалын хорооны үйл ажиллагааг идэвхжүүлж, IDCXS 2022:02 баталгаажуулалтыг дахин амжилттай хамгаалан, ISO/IEC 27001:2013 стандартын хэрэгжилтээ үргэлжлүүлэв. Цаашид тогтвортой санхүүжилт, хүртээмжтэй нийгэм, хариуцлагатай засаглалыг урт хугацааны үнэ цэнийн үндэс болгон бататгаж ажиллана.

## Б. Хуншагай

Нэткапитал санхүүгийн групп
Гүйцэтгэх захирал

# Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйл, Соёл.

## Эрхэм зорилго | Mission

AI First Company

## Алсын хараа | Vision

AI Bank, Digital Bank, Commercial Bank-г нэгтгэсэн AI-First экосистемийг бүтээх.

## Үнэт зүйл | Value

- Эрч хүчтэй байж бусдыг энергижүүлнэ
- Ил тод байж, итгэл даана
- Гал эрмэлзэлтэй байна
- Хурдтай гүйцэтгэл
- Хөгжилтэй байх

## Бидний соёл | Culture

- Эерэг хандлага
- Эрсдэлд суурилсан сэтгэлгээ
- Мэргэжлийн баг
- Залуу манлайлал
- Тасралтгүй суралцах
- Амжилтад тэмүүлэгч

# БОНЗ-ын хөгжил.

**2020**

Тогтвортой Санхүүжилтийн Холбооны үндсэн гишүүн болж, ТоС-ийн 8 зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүллээ.

**2021**

Байгаль орчин, нийгмийн анхны бодлогоо баталж, тогтвортой санхүүжилтийн суурийг бий болголоо.

**2022**

“Тогтвортой санхүүжилтийн бодлого”-ыг шинэчлэн баталж, дотоод тогтолцоог боловсронгуй болголоо.

**2023**

БОНЗ-ын үнэлгээ хийх зээлийг автоматаар таньдаг систем нэвтрүүлж, “Чип” ногоон зээлийг зах зээлд гаргалаа.

**2024**

Эрсдэлийн зэрэглэлээр шууд хянах удирдлагын дашбоардыг хөгжүүлж нэвтрүүллээ.

**2025**

ТУЗ-ийн дэргэд Тогтвортой хөгжил, нийгэм, засаглалын хороог байгуулж, IDCXS, ISO 27001:2013 дахин баталгаажуулав.

# 2025 оны онцлох үйл явдлууд.



### Дуатлон

Монголын Триатлоны Холбоотой хамтран ажиллаж, спортын хөгжилд хувь нэмэр оруулав.

Спорт



### Волейбол MNVL

Монголын Үндэсний Волейболын дээд лиг 2025–2026 онд ерөнхий ивээн тэтгэгчээр хоёр дахь жилдээ ажиллав.

Спорт



### The Voice of Mongolia

Шилдэг дуу хоолой шалгаруулах шоу нэвтрүүлгийн 4-р улирлын ерөнхий ивээн тэтгэгч болов.

Соёл



### Net Future 50

Сүндий сангийн санаачилгаар 300+ оюутнаас шилдэг 50-ийг шалгаруулан, ирээдүйн манлайлагчдыг дэмжив.

Боловсрол



### Зүрх мартахгүй төсөл

“Бундан” ТББ-тай хамтран 24 хүүхдийн зүрхний хагалгааг дэмжив.

Эрүүл Мэнд

БОДЛОГО · ҮНЭЛГЭЭ · ХЯНАЛТ

# БОНЗ БА КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ.

01

# Засаглалын бодлогын тогтолцоо.

## САЛБАРЫН ҮНЭЛГЭЭ

**96%**

**2025 ОНЫ КОДЕКС ҮНЭЛГЭЭ**

Компанийн засаглалын хүрээнд өндөр гүйцэтгэлтэй ажиллаж, салбарын тэргүүлэгч компаниудын эгнээнд тогтвортой байр сууриа баталгаажууллаа.

## БОДЛОГО, ЖУРМЫН ТОГТОЛЦОО

- **Зээлийн БОНЗ эрсдэлийн журам**
- **Эрсдэлийн удирдлагын ерөнхий журам**
- **Нийцлийн эрсдэлийн ерөнхий журам**
- ШИНЭЧЛЭВ · 2025.12.23
  **Жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлого**
  ТУЗ-ийн хурлаар батлагдсан
- **Тогтвортой санхүүжилтийн бодлого**
- **Шүгэл үлээх бодлого**
- **Ёс зүйн дүрэм**

**КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН НЭГДСЭН ХҮРЭЭ — 7 БОДЛОГО**

# Жендерийн тэгш байдал.

Нэткапитал Санхүүгийн Групп нь жендерийн эрх тэгш байдалд хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг бөгөөд Хөдөлмөрийн дотоод журам болон Ёс зүйн дүрэмд тусгасан "Жендерийн тэгш байдлын бодлого"-ыг боловсруулан ажиллаж байна.

**703** НИЙТ АЖИЛТАН
2025 оны жилийн эцэст

## ХҮЙСИЙН ХАРЬЦАА

| | Тоо | Эмэгтэй | Эрэгтэй |
|---|---|---|---|
| Нийт ажилтан | 703 | 63.1% | 36.9% |
| Захирал, удирдлага | 76 | 35.5% | 64.5% |
| ТУЗ-ийн гишүүд | 7 | 71.4% | 28.6% |
| Харилцагчид | | 49.3% | 50.7% |

**41.5** Нэг ажилтанд ногдох сургалтын дундаж

**31.6** Ажилтнуудын дундаж нас

**20** Дадлагажуулах хөтөлбөрт хамрагдсан оюутан

ҮЙЛ АЖИЛЛАГАА · НОГООН САНХҮҮЖИЛТ · НИЙГЭМ

# Тогтвортой үйл ажиллагаа ба санхүүжилт.

02

# Олон улсын стандартын хэрэгжилт.

IDCXS

**Excellence түвшин · Дахин баталгаажсан**

IDCXS 2022:02 — Дижитал хэрэглэгчийн туршлагын стандарт

95.83%

2025 онд IDCXS 2022:02 стандартын баталгаажуулалтыг амжилттай дахин хамгаалж, 2 дахь жилдээ 95% буюу “Олон улсын тэргүүлэгч” түвшинд хүрснийг Их Британийн Стандартын Институт (BSI) баталгаажууллаа.

Ингэснээр бид харилцагч төвтэй үйлчилгээний бодлого, үйл ажиллагааны уялдаа, чанарын удирдлагын тогтолцоо олон улсын шаардлагад нийцэж буйг дахин бататгав.

IDCXS

**Баталгаажуулах аудит хийгдлээ**

ISO/IEC 27001:2013

3-р жил

ISO/IEC 27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог 2025 онд хоёр дахь жилдээ амжилттай магадлан аудитлууллаа.

# Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа.

**351,800**
харилцагчид олгосон дижитал зээл

**26.4 тонн**
$CO_2$ хий байгальд ялгарахаас сэргийлэв

**3.5 сая**
хуудас цаас хэмнэв (нэг зээл = 10 хуудас)

### Шинэ салбар – Шинэ мод

Шинэ салбарын нээлтэд зориулж мод тарих уламжлалыг дотооддоо нэвтрүүлэн ажилладаг.

### Дижитал зээл, цаас хэмнэлт

Netpay апп-аар дамжуулан 351,800 хүнд дижитал зээл олгосноор 26,4 тонн цаас хэмнэлээ.

### Ногоон оффис

Хог хаягдлын ангилал, ногоон худалдан авалт, дотоод сургалтаар ногоон оффисын дадлыг бий болгож байна.

# Цаасгүй өдөр тутмын үйл ажиллагаа.

Бид өдөр тутмын үйл ажиллагаагаа бүрэн дижитал орчинд шилжүүлж, цаас хэрэглэхгүй ажиллах зарчмыг хэрэгжүүлж байна. Энэ нь манай байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны цогц бодлогын үндсэн тулгуур юм.

## Цаасгүй үйл ажиллагаа

**Дижитал дотоод процесс**

Бүх дотоод процессыг цахимжуулж, цаас хэрэглэхгүй ажиллах зарчмыг бодлогын түвшинд тогтоосон.

### Дижитал зээл олголт

Гэрээ байгуулалтаас зээл олголт хүртэл процессыг бүхэлд нь NetPay апп-аар дамжуулан цахим хэлбэрээр гүйцэтгэдэг.

### Цахим харилцаа

Дотоод зөвшөөрөл, харилцагчийн харилцаа, тайлан мэдээллүүдийг бүрэн дижитал орчинд явуулж байна.

### Цахим гарын үсэг

Гэрээ, баримт бичигт цахим гарын үсэг ашиглаж, цаас хэрэглэхгүйгээр баталгаажуулдаг.

**Бүх гэрээ, баримт бичиг цахимжсан · Дотоод үйл явц 100% цаасгүй · Ногоон оффисын дадал бүх ажилтанд**

ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРЧИМ

# “Зөв хүнийг, зөв албан тушаалд, зөв цагт”



Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, ёс зүйн дүрмийн хүрээнд хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, ажилтныг сонгон шалгаруулах, тогтоон барих, дасан зохицуулах, сургах, хөгжүүлэхэд анхаарч ажиллана.

## ДОТООД БОДЛОГО

- Шүгэл үлээх бодлого
- Ёс зүйн дүрэм
- Жендерийн тэгш байдал

## Дотоод сургалт ба ажилтны хөтөлбөрүүд

Ажилтны жилийн турш үргэлжлэх дотоод хөтөлбөр

**Шинэ ажилтны сургалт**
Дасан зохицуулах, чиглүүлэх анхны сургалт

**NetX**
Илтгэх ур чадвар, ажил олгогчийн нэр хүнд хөгжүүлэх

**NetCup**
Нэгдсэн спортын арга хэмжээ — багийн ур чадвар

**NetVibe**
Идэвхжүүлэлтийн арга хэмжээ — инноваци, оролцоо

**NetSummer**
Нэгдсэн зуны зугаалга — нэгдмэл соёл

**NetNaadam**
Үндэсний баяр наадмын арга хэмжээ — өв соёл

# Олон улсын санхүүжилтийн эх үүсвэр.

2025 онд олон улсын санхүүжилтийн эх үүсвэрийг тэлж, нийт татан төвлөрүүлсэн санхүүжилтийн үлдэгдэл 14.4 сая ам.долларт хүрэв. Дэлхийн тэргүүлэгч нөлөөллийн санхүүжилтийн түншүүдтэй хамтын ажиллагаагаа гүнзгийрүүллээ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**$3.0M**
сая ам. доллар

## Enabling Qapital

НӨЛӨӨЛЛИЙН САНХҮҮЖИЛТ

Швейцарь дахь нөлөөллийн санхүүжилтийн фондтой түншилж, бичил болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн эх үүсвэрийг шинээр татан төвлөрүүлэв.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**$11.4M**
сая ам. доллар

## Kilde Singapore

ДИЖИТАЛ ЗЭЭЛИЙН ПЛАТФОРМ

Сингапурын Kilde платформтой 2024 онд эхэлсэн хамтын ажиллагааг бэхжүүлж, дижитал зээлийн нэмэлт эх үүсвэрийг амжилттай татан төвлөрүүллээ.

# Харилцагчийн үйлчилгээ ба гомдлын удирдлага.

| | | | |
|---|---|---|---|
| **137,158** | **273** | **272** | **99.6%** |
| Нийт харилцагч | Хүлээн авсан санал, гомдол (2025) | Шийдвэрлэсэн (2025) | Шийдвэрлэлтийн хувь |

## Гомдол, маргаан шийдвэрлэх механизм

“Харилцагчийн дуу хоолойн бодлого”-ын хүрээнд санал, хүсэлт, гомдлыг салбар, утас, цахим суваг, сошиал медиагаар хүлээн авч, бүртгэн, хариуцсан нэгжид шилжүүлж, SLA хугацаанд шийдвэрлэн харилцагчид албан ёсоор хариу өгдөг.

2025 онд олон нийтээс хүлээн авсан 273 санал, гомдлын 272-ыг шийдвэрлэж, шийдвэрлэлтийн хувь 99.6% хүрсэн.

## IDCXS баталгаажуулалт (2025)

Манай компани харилцагчийн үйлчилгээ, гомдол шийдвэрлэх процессын стандартыг хангах зорилгоор 2024 онд IDCXS стандартаар амжилттай баталгаажиж, 2025 оны 10 сард дахин баталгаажуулсан.

Энэхүү баталгаажуулалт нь үйл ажиллагааны ил тод, тогтвортой байдал, дотоод аудит, KPI тайлагналын суурийг бэхжүүлж, давтан гомдлыг бууруулахад шууд нөлөөлсөн.

# Ногоон зээлийн багц ба бүтэц.

**5.2%**

Ногоон зээлийн багц нийт зээлийн багцад эзлэх хувь

Группийн нийт зээлийн багцын **5.2%**-ийг ногоон зээл бүрдүүлж, тогтвортой санхүүжилтийн чиглэлээр тууштай дэвшил гаргаж байна.

**2025 ОНЫ БАГЦ**

## Ногоон зээлийн бүтээгдэхүүн

| | |
|---|---|
| Өрхийн зээл | 9.2 тэрбум ₮ |
| Дижитал бараа | 3.8 тэрбум ₮ |
| Автомашины зээл | 0.24 тэрбум ₮ |
| Бусад | ≈ 7 сая ₮ |
| **НИЙТ** | **13.2 тэрбум ₮** |

# Ногоон автомашины зээл.

НОГООН АВТОМАШИНЫ ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

## Зээлийн нөхцөл

| Зээлийн Дээд Хэмжээ | Зээлийн Хугацаа | Урьдчилгаа Төлбөр | Санхүүжих Автомашин |
|---|---|---|---|
| **100 сая ₮** | **96 сар хүртэл** | **10%-иас дээш** | **Шинэ / 0 гүйлттэй** |

САРЫН ХҮҮ — УРЬДЧИЛГААНЫ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР



# Ногоон зээлийн багцын замын зураглал.

2030 он гэхэд зээлийн багцыг **122 тэрбум ₮**-т хүргэх стратегийн зорилт




## 3 ТҮЛХҮҮР ЗАРЧИМ

**Дотоод эх үүсвэр**
Хадгаламж, харилцахаас бүрдсэн үндсэн санхүүжилтийн тулгуур

**Тогтвортой өсөлт**
18% багцын зорилтод хүрэх дунд хэмжээний санхүүжилт

**Олон улсын түншлэл**
ОУ-ын ногоон сан болон хөгжлийн банкуудаас татах нэмэлт санхүүжилт

# Тогтвортой хөгжил рүү 2025 → 2030.

Автомашин, дижитал ногоон бараа, өрхийн дулаалга, бичил ЖДБ — **9.3× өсөлттэй 5 сегмент**




**НОГООН ЗЭЭЛИЙН ӨСӨЛТ · 2025 → 2030**

| НОГООН ЗЭЭЛ | 2025 | 2030 |
|---|---|---|
| **Авто** | 0.2Bn | **30.6Bn** 127× өсөлт |
| **Дижитал ногоон бараа** | 3.8Bn | **36.7Bn** 9.7× өсөлт |
| **Өрхийн дулаалга** | 9.2Bn | **42.8Bn** 4.7× өсөлт |
| **Бичил/ЖДБ ногоон** | — | **9.8Bn** шинэ |
| **Байгууллагын B2B** | — | **2.5Bn** шинэ |
| **НИЙТ** | 13.2Bn | **122.4Bn** 9.3× нийт |

# БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо.

**Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)**
Дэргэдэх Тогтвортой хөгжил, нийгэм, засаглалын хороо · Стратеги, бодлогын баталгаажуулалт

**Эрсдэлийн удирдлага хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч**
БОНЗ-ын эрсдэлийн ерөнхий хяналт, шийдвэр гаргалт

**Эрсдэлийн удирдлагын газар**
*Risk Management Department (RMD)*
БОНЗ-ын үнэлгээний аргачлал, хяналт, тайлагнал — хамгаалалтын 2-р шугам

**Бизнесийн нэгжүүд — Зээлийн газар, салбарууд**
*Business units — Loan dept. & branches*
Үнэлгээ хийх, мэдээлэл цуглуулах, харилцагчтай харилцах — хамгаалалтын 1-р шугам

**ДЭМЖЛЭГИЙН БОДЛОГО**

- **Тогтвортой санхүүжилтийн бодлого**
- **Зээлийн БОНЗ эрсдэлийн журам**
- **Эрсдэлийн удирдлагын ерөнхий журам**
- **Нийцлийн эрсдэлийн ерөнхий журам**
- **Жендерийн эрх тэгш байдлын бодлого**
- **Ёс зүйн дүрэм · Шүгэл үлээх бодлого**

# Зээлдэгчийн БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний процесс.

ЗЭЭЛИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАНД АВЧ ҮЗЭХ:
Үр дүнгийн хураангуй + Засаж сайжруулах төлөвлөгөө

**01**
**Хориглосон үйл ажиллагааны жагсаалт**
*Prohibited activities screening*
**20 үйл ажиллагаа**

**02**
**Салбарын анхан шатны үнэлгээ**
*Sector preliminary assessment*
**>50 сая ₮ · >12 сар**

**03**
**Байгууллагын БОНЗ-ын үнэлгээ**
*Borrower-level ESG assessment*
**5 шалгуур**

**04**
**Дэлгэрэнгүй БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ**
*Detailed ESG risk assessment*
**20 шалгуур + салбар**

## АВЧ ҮЗДЭГ ХҮЧИН ЗҮЙЛС

**Байгаль орчин**
*Environment*
Эрчим хүч/ХХЯ · Ус · Хог хаягдал· Биологийн төрөл зүйл · Уур амьсгалын эрсдэл

**Эрүүл мэнд, аюулгүй байдал**
*Health, safety & labour*
ХАБЭА · Барилга · Биет аюул · Хими/цацраг идэвхт бодисын хадгалалт

**Нийгэм**
*Social*
Орон нутаг · Газар ашиглалт · Уугуул иргэд · Соёлын өв · Жендер

**Салбарын онцлог (ТоС зарчмууд)**
*Sector-specific (MN Sustainable Finance)*
Уул уурхай · ХАА · Барилга · Үйлдвэрлэл · Ноос ноолуур

## САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**20** ангилал

- Хууль бус мансууруулах
- Мөрийтэй тоглоом / Casino
- Албадан хөдөлмөр
- Зэвсгийн үйлдвэрлэл
- Асбест · ПХБ · Озон
- Тусгай хамгаалалттай газар
- CITES амьтан, ургамал

**Үл тохирол гарвал → ТАТГАЛЗАХ**

# Зээлдэгчийн БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний процесс.

ЦОГЦ ХАНДЛАГА: БОНЗ-ын эрсдэлийн хүчин зүйл бүрийг БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нэгтгэн, тогтмол хяналт, тайлагнал, сайжруулалтаар удирдана.

## Байгаль орчин

Environmental

**100%**

Байгууллагын зээл БОНЗ үнэлгээнд хамрагдсан

### Гол хүчин зүйлс

- Уур амьсгалын эрсдэл, биет эрсдэл — үер, ган, зуд
- Уур амьсгалын эрсдэл, шилжилтийн эрсдэл хүлэмжийн хийн ялгаруулалт, амлалт
- Эрчим хүчний хэрэглээ, хог хаягдлын менежмент

### Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Зээлдэгчдэд БОНЗ үнэлгээ заавал хийх (20 шалгуур)
- Хүлэмжийн хийн ялгарлын тайлагналын бэлтгэл
- Цаасгүй ажлын урсгал, эрчим хүч хэмнэлттэй оффис

## Нийгэм

Social

**100%**

Ажилтан БОНЗ-ын сургалт хамрагдсан

### Гол хүчин зүйлс

- Жендерийн тэгш бус байдал, ажлын байрны харилцаа
- Ажилтны хөгжил, ур чадварын тогтворгүй байдал
- Зээлдэгчийн нийгмийн нөлөөлөл — орон нутаг, хөдөлмөр

### Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Жендерийн эрх тэгш байдлын бодлого баталж нэвтрүүлсэн
- Бүх ажилтанд БОНЗ + ёс зүйн сургалт зохион байгуулсан
- Шүгэл үлээх бодлого, нууцлалт суваг идэвхтэй

## Засаглал

Governance

**6**

Бодлого / журам шинэчилсэн (2025)

### Гол хүчин зүйлс

- Зээлийн чанарын эрсдэл, NPL-ийн өсөлт
- Зохицуулагч байгууллагын шинэ шаардлага, нийцлийн эрсдэл
- Зах зээлийн хүү, ханшийн хэлбэлзэл

### Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Эрсдэлд суурилсан үнэлгээ, олон үе шаттай зээлийн шийдвэр
- Гурван шугамын хамгаалалт — Бизнес · Эрсдэл
- · Дотоод аудит
- Аудит, нийцлийн хяналт, тогтмол тайлагнал

# 2025 оны зорилт, гүйцэтгэл.

**100%**
**Байгууллагын шинэ зээл БОНЗ үнэлгээ**
*New corporate loans — ESG screened*

**6**
**Шинэчилэн баталсан бодлого, журам**
*Policies adopted or revised*

**100%**
**Ажилтан БОНЗ сургалт хамрагдсан**
*Staff trained on ESG fundamentals*

| Чиглэл / Area | Зорилт / Goal | Гүйцэтгэл / Result | Төлөв |
|---|---|---|---|
| **БОНЗ ба засаглал** | Зээлийн БОНЗ үнэлгээ нэвтрүүлэх | 100% хэрэгжсэн | Хүрсэн |
| **Засаглалын бодлого** | Бодлого, журмыг шинэчлэх | 6/6 баримт бичиг | Хүрсэн |
| **Жендерийн тэгш байдал** | Бодлого батлах, нэвтрүүлэх | Батлагдсан, мөрдөгдөж буй | Хүрсэн |
| **Хүний нөөц, сургалт** | БОНЗ + ёс зүйн сургалт | 100% ажилтан хамрагдсан | Хүрсэн |
| **Тогтвортой санхүүжилт** | Бүтээгдэхүүн өргөжүүлэх | Үргэлжилж байгаа | Үргэлжилж |
| **ХХЯ-ын тайлагнал** | Тайлагналын бэлтгэл хангах | Арга зүй боловсруулсан | Үргэлжилж |

АЛСЫН ХАРАА · ХИЙГДЭХ АЖЛУУД

# Тогтвортой хөгжлийн алсын хараа.

03

# Алсын хараа ба хийгдэх ажлууд.

Групп нь нийгмийн хариуцлагын ажлуудыг жил бүр зохион байгуулж, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулдаг.
Бид алсын хараандаа дараах таван тулгуурыг тусган ажиллана.

Хийгдэх ажлууд:

- ✓ Ажлын байр нэмэгдүүлэх
- ✓ Ногоон зээлийг нэмэгдүүлэх
- ✓ Жишиг ногоон оффис
- ✓ Агаарын бохирдлыг бууруулах бүтээгдэхүүн

**Жендерийн тэгш байдал**

Хүртээмжтэй ажлын байр

**Тогтвортой байдал**

Урт хугацааны хөгжлийн суурь

**Тогтвортой санхүүжилт**

Хариуцлагатай хөрөнгө оруулалт

**Уур амьсгалын эрсдэл**

Бууруулах, дасан зохицох

**Ногоон санхүүжилт**

Ногоон зээл, ногоон оффис

# Байгууллагын санхүүгийн хүртээмж.

ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ · 2025

**21** аймаг

**8** дүүрэг

*Монгол улсын газар нутгийн өргөн хүрээнд NetPay аппликейшнээр санхүүгийн үйлчилгээг хүргэж байна.*

NETPAY · ДИЖИТАЛ ПЛАТФОРМ

## Дэлхийн хаанаас ч, хэзээ ч зээл авах боломж

Нэг удаа гэрээ хийсний дараа NetPay аппликейшнээр дамжуулан хаанаас ч зээл авах боломжтой. Орон нутгийн санхүүгийн хүртээмжийг тэлж, нийгэмд тулгамдсан хэрэгцээтэй төслүүдийг хамтран хэрэгжүүлж байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ

- **Цэцэрлэг**
- **Эмнэлэг**
- **Нийтийн аж ахуй**
- **Эрүүл мэнд**
- **Мод тарих**

**21 аймаг · 8 дүүрэг · 5 нийгмийн чиглэл**

# Тогтвортой санхүүжилтийн бодлого.

Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК-ийн тогтвортой санхүүжилтийн бодлого нь Группээс Монгол Улсын урт хугацааны хөгжлийг хангах, байгаль орчин, нийгэм, засаглалын зорилгуудыг биелүүлэхэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэхэд оршино.

01

**Зээлийн эх үүсвэр татах**

Олон улсын нөлөөллийн санхүүжилт, дотоодын зах зээлээс эх үүсвэрийг тэлэх.

02

**Ногоон зээл олгох**

Ногоон бизнес эрхлэгч, хувь хүмүүст зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүн.

03

**БОНЗ-ын үнэлгээ**

Зээлийн хүсэлтэд Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээг хийх.

04

**Бичил, ЖДБ-ийг дэмжих**

Бичил бизнесийн зээлийг нэмэгдүүлж, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих.

# Стратегийн тэргүүлэх чиглэлүүд.

Алсын хараа 2050, Парисын хэлэлцээр, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулан Группийн ирээдүйн хөгжлийг тодорхойлох дөрвөн стратегийн чиглэлийг тогтоосон. Эдгээр чиглэлээр тодорхой зорилт, хэмжүүр, хариуцлагын тогтолцоог цаашид хөгжүүлнэ.

### Тогтвортой санхүүжилт

- Хариуцлагатай бизнесийг дэмжих
- Ногоон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Зээлийн БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ
- ОУ-ын санхүүгийн байгууллагуудтай харилцаа ба санхүүжилт
- ОУ-ын ба дотоодын тогтвортой санхүүжилтийн санаачилгууд

### Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт

- Компанийн нийгмийн хариуцлагын стратеги ба сан
- Нийгмийн хариуцлагын төсөл, хөтөлбөрүүд

### Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал

- Үйл ажиллагааны, санхүүгийн, ТоС-ийн жилийн тайлангууд
- Хөрөнгө оруулагч, хамтрагч, зохицуулагч байгууллагуудын асуулга, тайлан
- Аудит ба оролцогч талуудын оролцоо

### Тогтвортой үйл ажиллагаа

- Хүний нөөцийн бодлого ба тогтвортой ажлын байр
- Компанийн засаглал
- Байгальд ээлтэй ажлын орчин
- Олон талт, хүртээмжтэй үйл ажиллагаа
- Мэдээллийн аюулгүй байдал ба хяналт шалгалт

# Баярлалаа

ТоС тайлан · 2025

Дижитал шилжилтээр манлайлна.

**Төв оффис**
info@netcapital.mn

**Утас**
+976 7500-6666

**И-мэйл**
СБД, 1-р хороо, Олимпийн гудамж 19, Шангри-Ла оффис, 2201 тоот

**Цахим Суваг**
facebook.com/Netcapital Financial Group
NetPay App